

**БАНКНЫ ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙГ ТОГТООХ,  
ТООЦОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

***Нэг. Нийтлэг үндэслэл***

1.1. Монголбанкнаас мөнгөний бодлого болон макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалах зорилгоор банкны заавал байлгах нөөцийг хуульд заасны дагуу тогтоох, тооцох, хангалтад хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

***Хоёр. Заавал байлгах нөөцийг тогтоох***

- 2.1. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан банкин дахь харилцах данс, хадгаламжийн үлдэгдэл болон Монголбанкнаас тогтоосон банкны бусад пассивын дүнг банкны заавал байлгах нөөцийн эх үүсвэрт тооцно.
- 2.2. Заавал байлгах нөөцийн шаардлага нь банкны хангалтын хугацааны дунджаар төвлөрүүлэх бэлэн нөөцийн доод хэмжээ байна.
- 2.3. Заавал байлгах нөөцийн хангалтын хугацаа нь долоо хоногийн Лхагва гарагаас эхлэн хуанлийн өдөр бүрийг хамарч, 2 дахь долоо хоногийн Мягмар гарагийн дүнг оруулснаар дуусгавар болно.
- 2.4. Банкны заавал байлгах нөөцийн шаардлагыг тухайн банкны заавал байлгах нөөцийн суурин тайлант хугацааны дундаж үлдэгдлийг заавал байлгах нөөцийн хувь хэмжээгээр үргүүлэн хангалтын хугацаанд мөрдүүлэхээр Монголбанкнаас тогтооно.
- 2.5. Заавал байлгах нөөцийн суурийг энэ журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу тухайн банкны тайлан тэнцэлд байршсан бусдаас татан төвлөрүүлсэн төгрөгийн болон гадаад валютын эх үүсвэрийн (төгрөгийн илэрхийллээр) тайлант хугацааны үлдэгдлээс заавал байлгах нөөц тооцоход хамаarahгүй болон заавал байлгах нөөц тооцоход хасч тооцох эх үүсвэрийг тус тус хасч тооцно.

2.5.1. Төгрөгийн заавал байлгах нөөцийн суурийг дараах томъёогоор тооцно:

$$T4 = T1 - T2 - T3$$

- |    |   |
|----|---|
| T1 | - Банкны тайлан тэнцэлд байршсан бусдаас татан төвлөрүүлсэн төгрөгийн эх үүсвэрийн үлдэгдэл |
| T2 | - Заавал байлгах нөөц тооцоход хамаarahгүй төгрөгийн эх үүсвэр                              |
| T3 | - Заавал байлгах нөөц тооцоход хасч тооцох төгрөгийн эх үүсвэр                              |
| T4 | - Төгрөгийн заавал байлгах нөөцийн суурь  |

2.5.2. Гадаад валютын заавал байлгах нөөцийн суурийг дараах томъёогоор тооцно:

$$B4 = B1 - B2 - B3$$

- |    |  |
|----|--|
| B1 | - Банкны тайлан тэнцэлд байршсан бусдаас татан төвлөрүүлсэн гадаад валютын эх үүсвэрийн үлдэгдэл |
| B2 | - Заавал байлгах нөөц тооцоход хамаarahгүй гадаад валютын эх үүсвэр                              |
| B3 | - Заавал байлгах нөөц тооцоход хасч тооцох гадаад валютын эх үүсвэр                              |

*B4 - Гадаад валютын заавал байлгах нөөцийн суурь*

- 2.6. Дотоодын банк хоорондын захаас татсан болон Монголбанкнаас авсан банкны эх үүсвэрийг банкны заавал байлгах нөөц тооцоход хамаарулахгүй.
- 2.7. Монголбанк мөнгөний болон макро зохистой бодлогын зорилгоор тодорхой хугацаанд зарим төрлийн эх үүсвэрийг банкны заавал байлгах нөөц тооцоход хасч тооцож болно. Заавал байлгах нөөц тооцоход хасч тооцох эх үүсвэрийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 2.8. Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг Мөнгөний бодлогын хороо тогтооно. Монголбанк бодлогын арга хэмжээний хүрээнд заавал байлгах нөөцийн хувь хэмжээг банкны эх үүсвэрийн хугацаа болон төрлөөс хамааруулан ялгаатай тогтоож болно.
- 2.9. Монголбанк заавал байлгах нөөцийн хувь хэмжээг банкны эх үүсвэрийн төрлөөр ялгаатай тогтоосон тохиолдолд тэдгээр эх үүсвэрийг тайлагнах загварыг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад нэмж тусгана.
- 2.10. Заавал байлгах нөөцийн мэдээгээр банкнаас заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрийн дунг тайлант хугацааны өдөр бүрийн үлдэгдлээр энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу харуулна.
- 2.11. Банк заавал байлгах нөөцийн мэдээг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргаж, тайлант хугацаа дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан Банкны тайлан бүртгэлийн системээр болон зохих албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан хэвлэмэл хэлбэрээр Монголбанкинд ирүүлнэ.
- 2.12. Тайлант хугацаа нь заавал байлгах нөөц тооцох суурьт хамаарах эх үүсвэрийн үлдэгдлийн мэдээллийг хамруулах 2 долоо хоногийг хэлнэ.
- 2.13. Банкнаас ирүүлсэн тайлант хугацааны заавал байлгах нөөцийн мэдээнд үндэслэн нэг удаагийн хангалтын хугацааг алгасч, дараагийн хангалтын хугацаанд мөрдөх Заавал байлгах нөөцийн хэмжээг тогтооно.
- 2.14. Монголбанк нь энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан аргачлалын дагуу банкны төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хэмжээг тооцож, хангалтын хугацаа эхлэхээс ажлын 3 өдөрт багтаан банкинд мэдэгдэнэ.

***Гурав. Банкны заавал байлгах нөөцийн хангалт***

- 3.1 Банк нь заавал байлгах нөөцийн хангалтын хугацаанд Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн шаардлагыг өдрөөр болон дунджаар нэгэн зэрэг хангах үүрэгтэй.
- 3.2 Банк заавал байлгах нөөцийн шаардлагыг бэлэн нөөц буюу тухайн банкны Монголбанкин дахь төгрөгийн болон валютын харилцах дансны үлдэгдлээр хангана.
- 3.3 Банк Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөцийн хэмжээг заавал байлгах нөөцийн хангалтын хугацаанд өдрийн эцэст мөрдөж ажиллана.

- 3.4 Банк хангалтын хугацааны турш өдөр бүр хамгийн багадаа заавал байлгах нөөцийн шаардлагын өдрөөр хангах хувь хэмжээнд харгалзах бэлэн нөөцийг Монголбанкны харилцах дансандаа төвлөрүүлснээр өдрийн шаардлагыг хангасанд тооцно. Өдрийн шаардлагыг хангах хувь хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.
- 3.5 Хангалтын хугацаанд банкны төвлөрүүлсэн бэлэн нөөцийн дундаж дүн нь заавал байлгах нөөцийн тогтоосон хэмжээг бүрэн хангаснаар заавал байлгах нөөцийн шаардлагыг дунджаар хангасанурамд тооцно.
- 3.6 Банк төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлагыг Монголбанкин дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдлээр, гадаад валютын заавал байлгах нөөцийн шаардлагыг Монголбанкин дахь гадаад валютын харилцах дансны үлдэгдлээр тус тус хангана.
- 3.7 Монголбанк бодлогын зорилгоор төгрөг болон гадаад валютын заавал байлгах нөөцийн шаардлагыг дараах хэлбэрээр тус тус хангаж болно:
- 3.7.1 Валютын заавал байлгах нөөцийг төгрөгийн бэлэн нөөцөөр, эсхүл төгрөгийн заавал байлгах нөөцийг валютын бэлэн нөөцөөр;
  - 3.7.2 Төгрөгийн заавал байлгах нөөцөө хангаж, илүү гарсан хэмжээгээр валютын заавал байлгах нөөцийг, эсхүл валютын заавал байлгах нөөцөө хангаж, илүү гарсан хэмжээгээр төгрөгийн заавал байлгах нөөцийг тус тус хангаж болно.
- 3.8 Заавал байлгах нөөцийг энэ журмын 3.7-д заасан хэлбэрээр хангуулах эсэхийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар шийдвэрлэнэ.

#### *Дөрөв. Банкны заавал байлгах нөөцийн хангалтад хяналт тавих*

- 4.1 Монголбанк заавал байлгах нөөцийн шаардлагын биелэлтэд банк тус бүрээр хяналт тавина.
- 4.2 Банкны заавал байлгах нөөцийн шаардлагыг хангасан хэсэгт ногдох бэлэн нөөцөд Монголбанкаас урамшууллын хүү төлж болно. Заавал байлгах нөөцийн урамшууллын хүүгийн хувь хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 4.3 Энэ журмын 4.2-т заасан урамшууллын хүүг дараах томъёогоор тооцно:

$$УХ = \frac{УТС \times rr \times 14}{365}$$

- УХ - Заавал байлгах нөөцийн шаардлагыг хангасан банкинд олгох урамшууллын хэмжээ
- УТС - Урамшууллын хүү тооцох суурь буюу заавал байлгах нөөцийн шаардлагыг хангасан хэсэг
- rr - Заавал байлгах нөөцийн урамшууллын жилийн хүүний хувь хэмжээ<sup>1</sup>

---

<sup>1</sup> Хангалтын хугацаанд урамшууллын хүү өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн шинээр тогтоосон хүүг мөрдөнө.

- 4.4 Монголбанк заавал байлгах нөөцийн шаардлагыг өдрөөр, эсхүл дунджаар хангаагүй банкинд торгууль ногдуулна.
- 4.5 Торгууль ногдуулсан банкинд энэ журмын 4.2-т заасан урамшууллын хүү төлөхгүй.
- 4.6 Торгуулийн нийт хэмжээ нь өдрөөр болон дунджаар хангаагүйд ногдуулах торгуулийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

Өдрөөр хангаагүйд ногдуулах торгуулийн хэмжээг дараах томъёогоор тооцно:

$$T_{\theta} = \sum_{i=1}^{14} \left( (n \times ЗБН - БН_i) \times \frac{pr}{365} \right)$$

- $T_{\theta}$  - Заавал байлгах нөөцийн хэмжээг өдрөөр хангаагүйд ногдуулах торгуулийн хэмжээ
- $n$  - Заавал байлгах нөөцийн өдрийн шаардлагыг хангах хувь хэмжээ
- ЗБН - Хангалтын хугацаанд тогтоосон заавал байлгах нөөцийн хэмжээ
- $БН_i$  - Заавал байлгах нөөцийн өдрийн шаардлагыг хангаагүй өдөрт харгалзах бэлэн нөөцийн хэмжээ
- $pr$  - Заавал байлгах нөөцийн торгуулийн хувь хэмжээ<sup>2</sup>

Дунджаар хангаагүйд ногдуулах торгуулийн хэмжээг дараах томъёогоор тооцно:

$$T_d = \left( ЗБН - \frac{\sum_{j=1}^{14} БН_j}{14} \right) * \frac{pr}{365}$$

- $T_d$  - Заавал байлгах нөөцийн шаардлагыг дунджаар хангаагүйд ногдуулах торгуулийн хэмжээ
- ЗБН - Хангалтын хугацаанд тогтоосон заавал байлгах нөөцийн хэмжээ
- $БН_j$  - Хангалтын хугацааны өдөр бүрний бэлэн нөөцийн хэмжээ
- $pr$  - Заавал байлгах нөөцийн торгуулийн хувь хэмжээ<sup>3</sup>

- 4.7 Төгрөг болон гадаад валютын заавал байлгах нөөцийн шаардлагыг дутагдуулсанд ногдуулах торгуулийн хэмжээг банк тус бүрээр тооцож, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлан банкинд албан бичгээр мэдэгдэнэ.
- 4.8 Монголбанк ногдуулсан торгуулийг тухайн банкны Монголбанкин дахь харилцах данснаас төлүүлнэ.
- 4.9 Монголбанкны заавал байлгах нөөцийг хариуцсан газар нэгж заавал байлгах нөөцийн шаардлагыг 3 сараас дээш хугацаагаар үргэлжлүүлэн хангаагүй банкинд холбогдох арга хэмжээ авах саналыг банкны хяналт шалгалт хариуцсан газар нэгжид хүргүүлнэ.

<sup>2</sup> Хангалтын хугацаанд торгуулийн хувь хэмжээг өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн шинээр тогтоосон торгуулийн хувь хэмжээг өдрөөр хангаагүйд ногдуулах торгуулийн тооцоололд ашиглана.

<sup>3</sup> Хангалтын хугацаанд торгуулийн хувь хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд хангалтын хугацааны эхэнд мөрдөгдж байсан торгуулийн хувь хэмжээг дунджаар хангаагүйд ногдуулах торгуулийн тооцоололд ашиглана.

- 4.10 Заавал байлгах нөөцийн мэдээг үнэн зөв мэдээлж байгаа эсэхэд Монголбанк хяналт тавьж ажиллах бөгөөд алдаатай мэдээлэл ирүүлсэн банкинд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авна.
- 4.11 Заавал байлгах нөөцийн мэдээг энэхүү журмын 2.11-т заасан хугацаанд багтаан ирүүлээгүй банкинд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авна.
- 4.12 Монголбанкны заавал байлгах нөөц хариуцсан газар нэгж банкны заавал байлгах нөөцийн хангалтын талаарх мэдээллийг Монголбанкны удирдлагад тогтмол танилцуулна.

\_\_\_\_\_ oOo \_\_\_\_\_

## ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН МЭДЭЭ

(банкны нэр)

Тайлант хугацаа:

cap/өдөр/он

cap/өдөр/он

Валютын төрөл:

ТӨГРӨГ

Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь

... хувь

хэмжээ:

Д/д	Төгрөгийн заавал байлгах нөөц тооцох эх үүсвэр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	(Төгрөгөөр) 14 хоногийн дундаж
		.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...
T1	Заавал байлгах нөөц тооцох эх үүсвэр <sup>4</sup>															
T11	Харилцах															
T12	Хадгаламж															
T13	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр															
T14	Бусад эх үүсвэр															
T2	Заавал байлгах нөөц тооцоход хамаарахгүй эх үүсвэр															
T21	Монголбанкнаас олгосон эх үүсвэр															
T22	Банк хоорондын захаас татсан эх үүсвэр															
T3	Заавал байлгах нөөц тооцоход хасч тооцох эх үүсвэр															
T31	Засгийн газраас Монголбанкаар дамжуулан олгосон ипотекийн зээлийн эх үүсвэр (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-85 дугаар тушаал)															
T32	Ноолуур боловсруулах, алт олборлоход олгосон хөнгөлөлтгэй зээлийн дүнтэй тэнцэхүүц хэмжээний эх үүсвэр (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-83 дугаар тушаал)															
T33	Бага хүүтэй тэтгэврийн зээлийн эх үүсвэр (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-86 дугаар тушаал)															
T34	(1) Ипотекийн зээлийн санхүүжилтийн зориулалтаар олон улсын санхүүгийн зах зээл дээрээс татсан эх үүсвэр, (2) 1-т заасан эх үүсвэрээр ипотекийн зээл худалдан авснаар бий болох эх үүсвэртэй тэнцэхүүц хэмжээний эх үүсвэр (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-91 дүгээр тушаал )															
T4	Төгрөгийн заавал байлгах нөөцийн суурь (T1 – T2 – T3)															
T5	ТӨГРӨГИЙН ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ	ЗБН <sub>төгрөг</sub> = T4 × Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ														

Заавал байлгах нөөцийн мэдээг үнэн зөв мэдээлсэн болохыг баталгаажуулж:

Мэдээ гаргасан:

/албан тушаал/

/гарын үсэг/

/овог, нэр/

Хянасан:

/албан тушаал/

/гарын үсэг/

/овог, нэр/

/Тамга,  
тэмдэг/<sup>4</sup> Заавал байлгах нөөц тооцоход хамаарахгүй болон хасч тооцох эх үүсвэрийн дүнг оруулсан байна.

## ТӨСӨЛ

“Банкны заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журам”-ын

1-Б дүгээр хавсралт

## ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН МЭДЭЭ

(банкны нэр)

Тайлант хугацаа:

cap/өдөр/он

- cap/өдөр/он

ГАДААД ВАЛЮТ

... хувь

Валютын төрөл:

Гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь

хэмжээ:

Д/д	Гадаад валютын заавал байлгах нөөц тооцох эх үүсвэр	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	(Төгрөгөөр) 14 хоногийн дундаж
		.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	.../...	
B1	Заавал байлгах нөөц тооцох эх үүсвэр <sup>5</sup>															
B11	Харилцах															
B12	Хадгаламж															
B13	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр															
B14	Бусад эх үүсвэр															
B2	Заавал байлгах нөөц тооцоход хамаарахгүй эх үүсвэр															
B21	Монголбанкнаас олгосон эх үүсвэр															
B22	Банк хоорондын захаас татсан эх үүсвэр															
B3	Заавал байлгах нөөц тооцоход хасч тооцох эх үүсвэр															
B31	3 жил болон түүнээс урт хугацаатай бонд болон зээл хэлбэрээр татсан гадаад валютын эх үүсвэр (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-84 дүгээр тушаал)															
B32	Ноолуур боловсруулах, алт олборлоход олгосон хөнгөлөлттэй зээлийн дүнтэй тэнцэхүйц хэмжээний эх үүсвэр (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-83 дугаар тушаал)															
B4	Гадаад валютын заавал байлгах нөөцийн суурь (B1 – B2 – B3)															
B5	ГАДААД ВАЛЮТЫН ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ	ЗБН <sub>гадаад валют</sub> = B4 × Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ														

Заавал байлгах нөөцийн мэдээг үнэн зөв мэдээлсэн болохыг баталгаажуулж:

Мэдээ гаргасан:

/албан тушаал/

/гарын үсэг/

/овог, нэр/

Хянасан:

/албан тушаал/

/гарын үсэг/

/овог, нэр/

/Тамга,  
тэмдэг/<sup>5</sup> Заавал байлгах нөөц тооцоход хамаарахгүй болон хасч тооцох эх үүсвэрийн дүнг оруулсан байна.

## ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН МЭДЭЭ БОЛОН БАНКНЫ ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу ирүүлсэн заавал байлгах нөөцийн мэдээ нь банкны дэлгэрэнгүй тайлан тэнцлийн холбогдох дансдын үлдэгдэлтэй нийцтэй<sup>6</sup> байна. Нийцтэй байх дансдыг хүснэгтэд харуулав.

### Хүснэгт 1. Заавал байлгах нөөцийн мэдээ, банкны дэлгэрэнгүй тайлан тэнцлийн холбогдох данс

Д/ д	Заавал байлгах нөөцийн мэдээний үзүүлэлтүүд <sup>7</sup>	Дэлгэрэнгүй тайлан тэнцлийн холбогдох данс
1.	T11 + B11	21000000
2.	T12 + B12	22000000
3.	T13 + B13	23000000
4.	T14 + B14	24000000
5.	T21 + B21	23110000+23161000+23210000+23310000+23410000+23510000+2441000+24841000
6.	T22 + B22	23120000+23162000+23220000+23320000+23420000+23520000+2442000+24842000+24510000+24851000
7.	T3	Заавал байлгах нөөц тооцоход хамаарахгүй байх эх үүсвэрийн төрлөөс хамаарна.

Жишээ нь, T11 + B11 буюу заавал байлгах нөөцийн мэдээнд ирүүлсэн төгрөгийн харилцах болон гадаад валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэр нь банкны дэлгэрэнгүй тайлан тэнцэл дээрх 21000000 дугаартай дансны дүнтэй нийцтэй байна.

<sup>6</sup> Заавал байлгах нөөцийн мэдээний сарын эцсийн өдөрт харгалзах үзүүлэлтүүд банкны тайлан тэнцлийн дүнтэй тэнцүү байна.

<sup>7</sup> “Заавал байлгах нөөцийн журам”-ын 1 дүгээр хавсралт.

“Банкны заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журам”-ын  
3 дугаар хавсралт

## ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН ТООЦООЛЛЫН ЖИШЭЭ

### 1. Заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоох

Монголбанк зурагт харуулсны дагуу 1 дэх 14 хоногийн тайлан мэдээнд үндэслэн 3 дахь 14 хоногийн заавал байлгах нөөцийн хэмжээг тогтооно. Үүний заавал байлгах нөөцийн хэмжээг нэг 14 хоногийн хоцрогдолтой тогтоох гэж нэрлэдэг. Журмын дагуу банк 1 дэх 14 хоног дууссанаас хойш ажлын 5 хоногт буюу 2 дахь 14 хоногийн эхний Мягмар гаригт багтаан Заавал байлгах нөөцийн мэдээг Монголбанкинд ирүүлсэн байна.



Заавал байлгах нөөцийн хэмжээг төгрөгийн болон гадаад валютын эх үүсвэрийн хувьд тус тусад нь тогтоож банкинд мэдэгдэнэ. Заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоох аргачлалыг А банкны жишээн дээр харуулъя.

Энэхүү жишээнд тайлант хугацааг 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 23-ны өдрийг дуусталх 14 хоног гэж үзье. Дээрх тайлант хугацаанд ирүүлсэн мэдээнд үндэслэн тогтоосон заавал байлгах нөөцийг хэмжээ нь банкны 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрөөс 20-ны өдрийг дуусталх хангалтын хугацаанд мөрдөгдөнө. Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 8 хувь гэж үзье.

Тайлант хугацаа (1 дахь 14 хоног):	05/10/2017-05/23/2017
Тайлант хугацаанд тогтоосон заавал байлгах нөөцийн хэмжээг мөрдөн ажиллах хугацаа (3 дахь 14 хоног):	06/07/2017-06/20/2017
Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ:	8% <sup>8</sup>

Д/д	Төгрөгийн заавал байлгах нөөц тооцох эх үүсвэр	(Төгрөгөөр)													14 хоногийн дундаж	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	
		5/10/2017	5/11/2017	5/12/2017	5/13/2017	5/14/2017	5/15/2017	5/16/2017	5/17/2017	5/18/2017	5/19/2017	5/20/2017	5/21/2017	5/22/2017	5/23/2017	
T1	Заавал байлгах нөөц тооцох эх үүсвэр <sup>9</sup>	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	610,000	
T11	Харилцах	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000
T12	Хадгаламж	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000	300,000
T13	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000	100,000
T14	Бусад эх үүсвэр	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000	10,000
T2	Заавал байлгах нөөц тооцоход хамаарахгүй эх үүсвэр	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000	200,000
T21	Монголбанкаас олгосон эх үүсвэр	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000	50,000
T22	Банк хоорондын захаас татсан эх үүсвэр	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000	150,000
T3	Заавал байлгах нөөц тооцоход хасч тооцох эх үүсвэр <sup>10</sup>	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
T31	-	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
T32	-	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
T3	Төгрөгийн заавал байлгах нөөцийн суурь [T1-T2-T3]	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000	410,000
T4	ТӨГРӨГИЙН ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ	ЗБН <sub>төгрөг</sub> = T4 × Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ													32,800	

<sup>8</sup> Заавал байлгах нөөцийн хүчин төглөр мөрдөгдж буй хувь хэмжээг ашиглана.

<sup>9</sup> Заавал байлгах нөөц тооцоход хамаарахгүй болон хасч тооцох эх үүсвэрийн дүнг оруулсан байна.

<sup>10</sup> Энэ жишээнд заавал байлгах нөөц тооцоход хасч тооцох эх үүсвэр байхгүй гэж үзэ.

А банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээ нь 32,800.00 төгрөг байна. А банкны гадаад валютын заавал байлгах нөөцийн хэмжээг ижил зарчмаар тооцно. Гэхдээ гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээ нь төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээнээс ялгаатай байж болохыг анхаарна уу.

## 2. Заавал байлгах нөөцийн урамшууллын хэмжээг тооцох

А банк 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрөөс 20-ны өдрийг дуусталх хангалтын хугацаанд төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн шаардлагыг зэрэг ханган ажилласан гэж үзье. Хэрэв төгрөгийн заавал байлгах нөөцийн тогтоосон хэмжээнд<sup>11</sup> жилийн 6.5 хувийн урамшууллын хүү олгодог гэж үзвэл тооцооллыг дараах байдлаар гүйцэтгэнэ.

Хангалтын хугацаа:	06/07/2017-06/20/2017
Хангалтын хугацаанд тогтоосон төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээ (ЗБН):	32,800 төгрөг
Урамшууллын хүү (rr) :	6.5% <sup>12</sup>

$$UH = \frac{UTC \times rr \times 14}{365} = 32,800.00 \times 0.065 \times \frac{14}{365} = 81.77 \text{ төгрөг}$$

## 3. Заавал байлгах нөөцийн торгуулийн хэмжээг тооцох

А банк 2017 оны 6 дугаар сарын 7-ны өдрөөс 20-ны өдрийг дуусталх хангалтын хугацаанд заавал байлгах нөөцийн шаардлагыг ханган ажиллаагүй бол банкинд ногдуулах торгуулийн тооцооллыг дараах байдлаар гүйцэтгэнэ.

Хангалтын хугацаа:	06/07/2017-06/20/2017
Хангалтын хугацаанд тогтоосон төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээ (ЗБН):	32,800.00 төгрөг
Өдрөөр хангах хувь хэмжээ (n):	50% <sup>13</sup>
Торгуулийн хүү (pr):	22%

Хангалтын хугацаа	А банкны бэлэн нөөц [BH <sub>i</sub> ]	Өдрийн хангалт [BH <sub>i</sub> - n × ЗБН]	Заавал байлгах нөөцийн шаардлагыг өдрөөр хангаагүйд ногдуулах торгуулийн тооцоолол [(n × ЗБН - BH <sub>i</sub> ) × pr / 365]
06/07/2017	17,000.00₮	17,000.00₮ - 0.5 × 32,800.00₮ = 600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
06/08/2017	18,000.00₮	1,600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
06/09/2017	16,000.00₮	-400.00₮	T <sub>e</sub> = (0.5 × 32,800.00 - 16,000.00) × 0.22 / 365 = 0.24
06/10/2017	16,000.00₮	-400.00₮	T <sub>e</sub> = 0.24
06/11/2017	13,000.00₮	-3,400.00₮	T <sub>e</sub> = 2.04
06/12/2017	17,000.00₮	600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
06/13/2017	20,000.00₮	3,600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
06/14/2017	28,000.00₮	11,600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
06/15/2017	30,000.00₮	13,600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
06/16/2017	10,000.00₮	6,400.00₮	T <sub>e</sub> = 3.85
06/17/2017	10,000.00₮	6,400.00₮	T <sub>e</sub> = 3.85
06/18/2017	17,000.00₮	600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
06/19/2017	30,000.00₮	13,600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
06/20/2017	30,000.00₮	13,600.00₮	Өдрийн шаардлагыг хангасан.
Нийт	272,000.00₮		10.22₮

Төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлагыг өдрөөр хангаагүйд ногдуулах торгуулийн хэмжээ:

$$T_e = \sum \left( (n \times ZBN - BH_i) \times \frac{pr}{365} \right) = 0.24 + 0.24 + 2.04 + 3.85 + 3.85 = 10.22 \text{ төгрөг}$$

Төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлагыг дунджаар хангаагүйд ногдуулах торгуулийн хэмжээ:

$$T_d = \left( ZBN - \frac{\sum_{i=1}^{14} BH_i}{N} \right) * \frac{m}{365} = \left( 32,800.00 - \frac{272,000.00}{14} \right) * \frac{0.22}{365} = 8.06 \text{ төгрөг}$$

Төгрөгийн заавал байлгах нөөцөд тогтоох нийт торгуулийн хэмжээ:

$$T = T_d + T_e = 8.06 + 10.22 = 18.28$$

Хэрэв А банк гадаад валютын заавал байлгах нөөцийн шаардлагыг хангаагүй бол торгуулийн тооцооллыг дээрх зарчмаар гүйцэтгэнэ.

<sup>11</sup> Зөвхөн төгрөгийн заавал байлгах нөөцийн тогтоосон хэмжээнд урамшууллын хүү олгодог тохиолдлыг авч үзэв.

<sup>12</sup> Урамшууллын хүү Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

<sup>13</sup> Өдрөөр хангах хувь хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.